



ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитынтайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Шинжээч А.Батлхагва

Утас: 70273204 96011185

И-мэйл: batlhagva617@gmail.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 6-р баг

Төрийн байгууллагуудын 2-р ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ТӨВ-2017/10/СТА-ТЕЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2016 оны төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 05-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн шинжээч А.Батлхагва хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2016 оны төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланг 2017 оны 03 дугаар сарын 05-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 05-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 31-нд Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн Ерөнхийлөн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг

зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.”, мөн хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 29.1.1.төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар: а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга буюу ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Мөн хуулийн 14.3 Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

Засаг дарга нь дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2016 оны төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга, санхүүгийн албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 9 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн системтэй танилцахад санхүүгийн тайланг Сангийн яамны е-тайлангийн нэгтгэлээр нэгтгэгдсэн санхүүгийн тайланг ирүүлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын төсвийн нэгтгэсэн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг тодоруулахад Дэлхийн банкны төслийн хүрээнд хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцсэн интернетэд суурилсан программ хангамжийг ашиглан “Санхүүгийн тайлангийн И- бланс” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг нь ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг гарган засаг даргын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг е-тайлангийн бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Зуунмод сум 2016 оны төсвийн орлогыг 3 шатанд 3914515.6 мянган төгрөгийн төсвийн эх үүсвэр бүрдүүлэхээр баталсанаас гүйцэтгэлээр 4308657.5 мянган төгрөг буюу 110.1 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 630900.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 706232.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж батлагдсан төлөвлөгөө 75332.9 мянган төгрөг буюу 11.9 хувиар давж биелсэн байна.

Аймагт төвлөрүүлэх татварын орлого 3018073.6 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 3310953.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөө 292879.9 мянган төгрөг буюу 9.7 хувиар давж биелэсэн байна.

Орон нутагт төвлөрүүлэх татварын орлого 10 нэр төрлийн 265542.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 14 нэр төрлийн 291471.1 мянган төгрөг төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөө 25929.1 мянган төгрөг буюу 9.8 хувиар давж биелэсэн байна.

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Татварын төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
ААНОАТ	73000.0	106169.2	145.4
НӨТ	515400.0	563750.1	109.4
Агаарын бохирдол	7500.0	9101.0	121.3
Онцгой	35000.0	23000.0	65.70
АМНАТ		4212.60	100.0
<u>Улсын төсөвт төвлөрүүлэх дүн</u>	<u>630900.0</u>	<u>706232.9</u>	<u>111.9</u>
АТБӨЯХ-ийн татвар	61077.0	151651.1	248.3
Газрын төлбөр	16800.0	160486.8	955.3
Үл хөдлөх хөрөнгийн татвар	62500.00	90556.8	144.9
ХХОАТ	2872696.6	2902668.4	101.0
Ус ашигласны татвар	5000.0	5590.40	111.8
<u>Аймагт төвлөрүүлэх дүн</u>	<u>3018073.6</u>	<u>3310953.5</u>	<u>109.7</u>
Мал	-	46.90	100.0
ОТБ/патент/	-		
ОБТ/жижиг/	-	131.4	100.0
Үйл ажиллаганы ОАТ	95000.0	26382.3	27.80
Суутган-2	48000.0	115046.8	239.7
ҮХЭХ борлуулсаны албан татвар	45332.0	35808.5	79.0
Бууны албан татвар	3180.0	3211.80	101.0
Улсын тэмдэгтийн хураамж	12500.0	12261.3	98.100
Ой мод ашигласны төлбөр		15.50	100.0
Ус ашигласны төлбөр		2442.0	100.0
Хог хаягдлын хураамж	50000.0	69839.2	139.7
Түрээсийн орлого	1200.0	1800.0	150.0
Төсвийн өөрийн орлого	330.0	66.60	20.20

Хүү торгууль	6000.0	22818.8	380.3
Нэр зааж ангилагдаагүй орлого	4000.0	1600.0	40.0
<u>Сүмэнд төвлөрүүлэх орлого</u>	<u>265542.0</u>	<u>291471.1</u>	<u>109.8</u>
<u>3 шатны орлого нийт дүнгээрээ</u>	<u>3914515.6</u>	<u>4308657.5</u>	<u>110.1</u>

Аймгийн ИТХ-ын 02-р хуралдааны 2016.12.02-ны 02 тоот тогтоолоор Зуунмод сумын НҮҮ нь 2016 онд төсөвт зардлын эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх орлогын шилжүүлгийг 37131.6 мянган төгрөгөөр бууруулан 117868.4 мянган төгрөгөөр, Хот тохижуулах газрыг 54518.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 360885.5 мянган төгрөгөөр тодотгож, Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тодотгосон төсөв Хүмүүн цогцолбор сургууль 3313607.8 мянган төгрөг, 4-р сургууль 560442.6 мянган төгрөг, 5-р сургууль 708944.0 мянган төгрөг Сент поуль сургууль 21409.1 мянган төгрөг Бүжинхэн цэцэрлэг 577032.1 мянган төгрөг, Дэгдээхий цэцэрлэг 323070.9 мянган төгрөг, Ирээдүй цэцэрлэг 615135.2 мянган төгрөг, Хүмүүн цэцэрлэг 155623.3 мянган төгрөг, Бумбардай цэцэрлэг 218687.7 мянган төгрөг, Унагалдайн андууд цэцэрлэг 177682.3 мянган төгрөг, Бяцхан найзууд цэцэрлэг 21288.0 мянган төгрөг, Адтай жаалууд цэцэрлэг 12914.0 мянган төгрөг, Мандах наран цэцэрлэг 10644.0 мянган төгрөгөөр тус тус нийт 6716481.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2015.12.18-ны 04 тоот тогтоолоор ЗДТГ-ын төсвийг оны эхэнд 597402.6 мянган төгрөгөөр Сумын ИТХ-ын төсвийг 56545.6 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ 155000.0 мянган төгрөг, Хот тохижуулах газрын төсвийг 306366.9 мянган төгрөг Сум хөгжүүлэх сангаас зарцуулах зардлыг 8266.7 мянган төгрөг нийт 1123581.8 мянган төгрөгөөр баталсан. Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлын хэмжээг Хүмүүн цогцолбор сургууль 3331937.6 мянган төгрөг, 4-р сургууль 496172.9 мянган төгрөг, 5-р сургууль 651462.1 мянган төгрөг Сент поуль сургууль 21409.1 мянган төгрөг Бүжинхэн цэцэрлэг 574988.3 мянган төгрөг, Дэгдээхий цэцэрлэг 341473.6 мянган төгрөг, Ирээдүй цэцэрлэг 602937.2 мянган төгрөг, Хүмүүн цэцэрлэг 76623.4 мянган төгрөг, Бумбардай цэцэрлэг 181057.7 мянган төгрөг, Унагалдайн андууд цэцэрлэг 174276.0 мянган төгрөг, Бяцхан найзууд цэцэрлэг 27957.0 мянган төгрөг, Адтай жаалууд цэцэрлэг 24229.0 мянган төгрөг, Мандах наран цэцэрлэг 13980.8 мянган төгрөгөөр тус тус нийт 65185504.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2016 оны 05-р сарын 18-ны өдрийн 02 тоот тогтоолоор Засаг даргын тамгын газрын 32553.1 мянган төгрөг, Нэмэлт санхүүжилтийн 15468.2 мянган төгрөг шилжих үлдэгдлийг нийт 48021.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан.

Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл 824.7 мянган төгрөг, аймгаас 117868.4 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 155000.0 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 26022.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор 2016 онд ОНХС-аас санхүүжүүлэхээр 4 ажилд 155000.0 мянган төгрөг баталсанаас

төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас гүйцэтгэлээр 4 ажил хийгдэхээр санхүүжилт авсан. 2016 онд санхүүжилт авсан ажлуудаас 7 ажил бүрэн хийгдэж дуусан комисст хүлээн өгч орлогот хүлээн авсан байна.

Сум хөгжүүлэх сан

Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1098086.9 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 233352.4 мянган төгрөг зээлэнд 83500.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 1190588.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 10 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2016 оны төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан үндсэн цалингийн зардлыг дүнгээр тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Орон нутагт төвлөрүүлэх татварын орлогын 4 нэр төрлийн 80804.6 мянган төгрөгийн 30.4хувиар тасарсан байна. Энэ нь “Төсвийн тухай хуулийн” 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих”, 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийн давтан гаргахгүй байхад анхаарч орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэх талаар санаачлагатай ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

2. Сум хөгжүүлэх сангийн 1109558.8 мянган төгрөгийн авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан 215879.2 мянган төгрөгийн зээлийг шүүхэд шилжүүлж 288075.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахаар албан шаардлага өгч нийт 504062.8 мянган төгрөгийн зээлийг барагдуулаагүй байна. НББТХуулийн 7 дугаар зүйлийн 7,4 аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", СТОУС Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн: Дээрх 504062.8 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг барагдуулан баталгаажуулж ирүүлэхээр зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Аудитын явцад алдаа залруулаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлтийг давтан шалгах асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2016 төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг бус хэмжээний 432258.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн зөрчлийг баталгаажуулж ирүүлэхээр зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын төсвийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас 1 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан төсвийн байгууллагууд дараах санал дүгнэлт авсан байна.Үүнд:

- Засаг даргын тамгын газар зөрчилгүй санал дүгнэлт
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал зөрчилгүй санал дүгнэлт
- Хот тохижуулах газар зөрчилгүй санал дүгнэлт
- Хүмүүн цогцолбор сургууль зөрчилгүй санал дүгнэлт
- 4-р сургууль зөрчилгүй санал дүгнэлт
- 5-р сургууль зөрчилгүй санал дүгнэлт
- Бүжинхэн цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
- Дэгдээхий цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
- Ирээдүй цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
- Хүмүүн цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
- Бумбардай цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
- Адтай жаалууд цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
- Унагалдайн андууд цэцэрлэг Хягаарлалтай санал дүгнэлт

Аудитлагдсан санхүүгийн тайлан 12 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: ШИНЖЭЭЧ

А.БАТЛХАГВА